

Хөлөнбуйрын цөөн тоот үндэстний ардын бүжгийн уламжлал, өвөрмөц онцлог

Гуо Саруул

Хөлөнбуйр дээд сургуулийн Хөгжим, бүжгийн сургууль,
Хөлөнбуйр, БНХАУ
✉ 1289544408@qq.com

Хураангуй: БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот нь монгол, дагуур, орчоон, эвенк зэрэг цөөн тоот үндэстнээс бүрдэх бөгөөд үндэстэн бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтой, ахуй соёлын арвин баялаг өв соёлыг хадгалан тээгч билээ. Бид энэ өгүүлэлдээ Хөлөнбуйрын цөөн тоот үндэстний дотроос хамгийн бага судлагдсан дагуур, орчоон үндэстэн нь оршин амьдрах газар нутаг, байгаль цаг уурын хувьд ижил боловч аж төрөх хэлбэр, шашин шүтлэг, ёс уламжлал өөр ард түмэн тул өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий бүжгийн хөдөлгөөн, түүнээ илтгэх ая дуутай байдгийг өөрсдийн биеэр явж судалсан хээрийн шинжилгээний дүндээ тулгуурлан гаргахыг хичээсэн болно.

Түлхүүр үгс: *Хөлөнбуйрын цөөн тоот үндэстэн, дагуур, орчоон, эвенк, ардын бүжиг, уламжлал, онцлог*

Traditions and Unique Characteristics of Folk Dance among Ethnic Minorities in Hulun buir

Guo Sarula

School of Music and Dance, Hulun buir University, Hulunbuir, China
✉ 1289544408@qq.com

Abstract: Hulun buir City, located in the Inner Mongolia Autonomous Region (IMAR) of the People's Republic of China, is home to several ethnic minorities, including the Mongols, Daur, Orchon, and Evenki. Each of these groups possesses its own distinct characteristics and rich cultural heritage. In this article, we focus on the Daur and Orchon peoples, who are among the least studied ethnic groups in Hulun buir. Although they share similar geographic and weather conditions, their lifestyles, faith and beliefs, and traditions differ significantly. As a result, their folk dances exhibit unique movements and accompanying melodies. Based on our field research, we aim to highlight the distinctive features of their dance traditions and the cultural expressions embedded within them.

Keywords: *Hulun buir's ethnic group, Daur, Orchon, Evenki, folk dance, tradition, feature*

Оршил

Хөлөнбуйр нь БНХАУ-ын ӨМӨЗО-ы үндсэн 12 нэгжийн нэг аймгийн дэстэй хот буюу тусгай эрхтэй хот юм. Хөлөнбуйр хотын төв нь Хайлаар хот бөгөөд нийт, 2,687,228 оршин суугчтай, дотроо хот хөдөөгөөс бүрдсэн 63,953 км² нутагтай, дэлхийн хамгийн том хот болно. Хөлөнбуйр хотын 81.85% нь хятад үндэстэн, 8.60% буюу 231,276 нь монгол үндэстэн, 9.55% нь бусад үндэстнээс бүрдэнэ. Тухайлбал, Хөлөнбуйрт 70,000 гаруй дагуур, 20,000 орчим орчоон, 140,000 гаруй эвенк үндэстэн оршин амьдарч байна. Энэ гурван үндэстэн язгуур бөөгийн шүтлэг болоод бурхны шашныг шүтдэг, эртнээс ой тайгаар амьдарч ирсэн араатан амьтан, загас зэрэг ан гөрөө эрхэлж амьдардаг нүүдэлчин угсаатан бөгөөд дагуур хэл нь алтай язгуурын монгол хэлний бүлэгт, орчоон, эвенк хэл нь манж түнгүс язгуурын хамниган хэлний бүлэгт харьяалагддаг, аль аль нь өөрийн гэсэн хэлээ хадгалж байгаа боловч бие даасан бичиг үсэггүй (Төвийн үндэстний их сургууль, 1974, 51). Тэд ардын бүжгээ хийхдээ бүжгийн хөдөлгөөнөө дэмнэж, хүч нэмэгдүүлэх өнгө аяс бүхий, дуу дуулж, дохио урааг өөр өөрийн хэлээр дуудаж байлаа.

Дэлхийн даяаршил, улс орны нийгмийн хөгжил, соёлын өөрчлөлтийг дагаад цөөн тоот үндэстний уламжлалт бүжгийн өв залгамжлал, хөгжилд олон бэрхшээл тулгарч байна. Тиймээс бид Хөлөнбуйрын үндэстний цөөнх болох дагуур, эвенк, орчоон үндэстний бүжгийн утга учир, өв залгамжлалын өнөөгийн байдлыг судлах, сурталчлах зорилгоор Хөлөнбуйрын гурван жижиг үндэстний хээрийн шинжилгээ хийсэн билээ.

Судалгааны арга зүй

Энэхүү тойм өгүүллийг бичигч нь Хөлөнбуйр хотын цөөн тоот үндэстний дунд аж төрөхийн зэрэгцээ тусгайлан дагуур, эвенк, орчоон үндэстний дунд 2023 оны 7-р сарын 20-оос 8-р сарын 30-ны хооронд Эвэнкийн өөртөө засах хошуу, Баянтал хотхон, Шинэ голын зүүн сум, Баянтохой хот, Эвэнк үндэстний сумдад хээрийн судалгаа хийсэн. Ингэхдээ түүврийн аргаар 31 хүнээс нийт 2 цаг 28 минутын ярилцлага судалгаа авч, тухайн үндэстний баяр наадмын үеэр ажиглалт судалгаа хийв. Судалгааны гол агуулга нь Хөлөнбуйрын гурван цөөн тоот үндэстний ардын бүжгийн өнөөгийн байдал, дуудлагын тэмдгийн утга зүй, удамшлын судалгаа юм. Судалгааны багийн гишүүд статистикийн судалгаагаар олж авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнд ардын бүжгийн дуудлагын утга, өв залгамжлалын талаар судалгааны тайлан бичсэн ажиглалт судалгаан дээр үндэслэн тус тойм өгүүллийг бичсэн болно.

Судалгааны зорилго: Хөлөнбуйрын цөөн тоот үндэстнүүдийн дунд хээрийн судалгаа хийж, дата мэдээлэл цуглуулах замаар эл үндэстний бүжгийн уламжлал, өнөөгийн байдал, өөр хоорондын ялгаа, өвөрмөц онцлогийг тодруулахыг зорилго болгов.

Судалгааны үр дүн

Хөлөнбуйрын цөөн тоот үндэстнүүдийн хүн ам, угсаатны аж төрөх ёс, зан заншлыг тодорхойлсон судалгаа байх боловч эвенк үндэстнээс бусад үндэстний үндэстний бүжгийн талаар тусгайлан бичсэн судалгааны бүтээл БНХАУ-д өнөө хэр гараагүй бололтой байна. Үүнээс үндэстэн тус тусын бүжгийн талаар дагнан судалсан бүтээлийн тухай ярихад юун түрүүн судлаач Хө Вэн жүнгийн бичсэн “Дагуур үндэстний ардын уламжлалт бүжгийн нэршлийг судалсан нь” (2013), “Дагуурчуудын уламжлалт ардын дуу, бүжгийн дагуур нэрийн тухай ярих нь” (2013) өгүүллийг дурдах нь зүй ёсны хэрэг. Учир нь судлаач тус өгүүллээ бичихийн тулд 2000-2010 оны хооронд хэд хэдэн удаа Хөлөнбуйрын тал нутагт удаа дараа очиж, тухайн үеийн хамгийн өндөр настай нутгийн иргэдтэй биеэр уулзаж учирч, аман сурвалжлага авч үлдээсэн нь өдгөө судалгааны үнэ цэнтэй баримт болон үлджээ. Энэ болон судлаач Ван Жяогийн “Дагуурчуудын анхны дуу бүжгийн үлдэгдэл -Хакумайл” (2004) өгүүлэл нь дагуур хэмээх нэрийн утга гарал, дагуур бүжгийн одоогийн байдлыг тодруулахад чухал ач холбогдолтой бүтээл болно.

Түүнчлэн, судлаач Үрэлтийн “Эвенкийн зан ааль” (1993), Оюундалайн “Эвенк үндэстний үүсэл хөгжил” (1997), доктор Цэрэнбатын “Эвенк үндэстний зан үйл” (2012), Асругийн “Эвэнк хүмүүсийн бүжгийн төрөл, хэлбэрийн товч дүн шинжилгээ” (2018), Лю Жун гуогийн “Эвэнк үндэстний ардын бүжиг, хөгжмийн урлагийн судалгаа” (2018) зэрэг бүтээлд эвенк бүжгийн талаар өгүүлжээ.

Орчоон бүжгийн талаар Ү Я жи профессорын “Сүүлчийн домог: Орчооны соёлын судалгаа” (2006), Лү Ян Чэний “Хөлөнбуйрын ардын бүжиг” (2007) гэх бүтээлд товч боловч дурдсан байна.

Харин Монгол Улсад Хөлөнбуйрын цөөн тоот үндэстний бүжгийн талаар хэд хэдэн ганц сэдэвт зохиол гарчээ. Тухайлбал, СУИС-ийн магистр Сацраа “ӨМӨЗО-ы эвенк үндэстний бүжгийн онцлог” (2012), Саруул “Дагуур үндэстний бүжгийн заах арга зүйн асуудлууд” (2017), Цэлмэг “Орчоон үндэстний бүжгийн заах аргын асуудлууд” (2017) гэх дипломын ажил бичиж, магистрын зэрэг хамгаалсан бол СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн багш, доктор Н.Содном, Б.Гэрэл нар 2017 оны 6 сарын 7-15-ны хооронд 7 хоногийн хугацаанд доктор Ш.Эрдэнэцэцгээр ахлуулан БНХАУ-ын Хөлөнбуйр нутагт хээрийн судалгаа хийсний үр дүнд “Барга, буриад, эвенк, орчоон бүжгийн судалгаа” (2023) хэмээх Хөлөнбуйрын 5 үндэстний бүжгийн талаар өгүүлсэн ном бичжээ. БНХАУ-ын цөөн тоот үндэстнүүдийн нэгээхэн хэсэг болох эвенк, дагуур угсаатнуудын ахуй соёл, эрхэлж буй аж ахуй болон хань үндэстний соёлын нөлөөлөл, орчин цагийн техник технологийн нөлөөлөл үндэстний бүжигт хэрхэн туссаныг тандах, Хөлөнбуйрын барга, буриадын бүжгийг Монгол Улсын барга, буриадын бүжгийн соёлтой харьцуулах, ялгаатай болоод нийтлэг талыг тодруулахыг зорьсон энэ судалгааны үр дүнд “цөөн тоот үндэстний ахуй амьдрал их гүрний бодлогоос болж устаж үгүй болоход их ойрхон болсон учир яаралтай соёлын өвд бүртгүүлж хамгаалах шаардлагатай” (Содном, Гэрэл 2023) хэмээн дүгнэсэн байдаг.

1. Дагуур бүжиг

Дагуур гэдэг нь “анхны газар”, “төрөлх хот” гэсэн утгатай үг юм (Хө Вэн жүн 2013, 178). Дагуурчууд хөгжилтэй, зоримог, ёс зүйд анхаардаг, сэтгэлийг эрхэмлэдэг, дуулж бүжиглэхдээ гаргууд үндэстэн бөгөөд урт удаан хөдөлмөр, амьдралын дадлагын явцад өөрийн гэсэн үндэсний онцлогтой олон хөгжим, дуу, ардын бүжгийг бий болгожээ.

Дагуурчууд эртнээс галын дэргэд хамтдаа тойрон бүжиглэдэг уламжлалтай. Тэдний өвөг дээдэс гүн уул, ойд түүдэг галын дэргэд ажиллаж амьдарч байсан ан агнуурын үеэс эхлэлтэй гэж үздэг. Энэ төрлийн ардын бүжгийг дагуураар “Лури жилэ” гэх бөгөөд лури гэдэг нь дуу, хөгжим гэсэн утгатай үг ажээ (Ли Вэй вэй 2023). Лури жилэ бүжигт ихэвчлэн хоёр хүн харьцангуй удаан бүжиглэж, голд нь үзүүлэнгийн эсвэл хүүрнэл зүйн завсарлагатай, оргил үетэй, хөгжилтэй өрсөлдөөнтэй бүжгээр төгсдөг. Уламжлалт Лури жилэ нь ямар ч хөгжмийн зэмсэггүй бүжиглэх бөгөөд уран бүтээлчид ар араасаа чанга чанга хашгирах юм уу тод, хатуу хэмнэлтэй ардын дууг ашиглан бүжгийг дагалдуулдаг. Дагуур үндэстний дунд өргөн дэлгэрсэн бас нэгэн бүжиг бол “Ханкенбай” хэмээх хамтын бүжгийн нэг төрөл юм (Ван Жяо 2004, 65). Энэ бүжгээ тэд хаврын баяраар, ургац хураалтын үеэр гэх мэт олуул цугласан дурын үедээ бүжин хөгжилдөж байна. “Ханкенбай” бүжгийг залуу эмэгтэйчүүд, өндөр настай хөгшчүүд ч бүжиглэх нь элбэг, харин эрэгтэйчүүд үүнд бараг оролцдоггүй, ихэвчлэн хажуугаас уухайлан дэмнэх байдалтай оролцож байв.

2. Орчоон бүжиг

Юань гүрний үед орчоон үндэстнийг “ойн жирийн хүмүүс”, “хойд уулсын зэрлэг хүмүүс” гэж, Чин гүрний эхэн үеийн баримт бичигт “ой модны хүмүүс” гэж тэмдэглэсэн байна. Судлаачид орчоон бүжгийг зан үйлийн бүжиг, зугаа цэнгэлийн бүжиг, шашны бүжиг (Ү Я жи 2006, 177), найр наадмын бүжиг, баавгайтай тулалдах бүжиг, эмэгтэйчүүдийн бүжиг, тахианы бүжиг, шашин суртахууны бүжиг (Эрдэнэцэцэг 2023, 10) гэж адил бус ангилсан байх бөгөөд эдгээр бүжиг нь дуу бүжиг хосолсон онцлогтой. Уламжлалын хувьд орчоончууд ан агнуураас буцаж ирэх болгондоо олуул гэр бүлээрээ түүдэг галын дэргэд цугларч, олзоо идэж, дараа нь дуулж бүжиглэдэг байв (Мин Сү линь 2023).

Орчоон нар баавгай тотемтой, эртний Сяньби нараас гаралтай гэж үздэг. Тайгын анчин гөрөөчин аймаг. Хувцас өмсгөл, зүүтгэл нь эрхэлдэг аж ахуйтай нь холбоотой. Тухайлбал, буга согоонуудыг дуудахад зориулж толгойн арьсаар нь малгай хийдэг, гутал нь чимээ гаргахгүй явахад зориулагдсан байдаг бөгөөд түүдэг тойрон бүжиглэдэг (Эрдэнэцэцэг 2023, 10).

Бүжгийн хэмнэл нь ихэвчлэн бие даасан хөгжөөнт дуу, бүжгээр амьтдын бие галбирыг дуурайлгасан хөдөлгөөн байна. Бүжгийн явцад хэмнэл нь удаанаас хурдан руу шилжиж, хүн бүр гар гараасаа хөтлөлцөн хөлөө дэвсэж, үе үе орилолдон бүжиглэнэ.

Орчоон үндэстний “Ихэ нанэн” бол овгийн цуглааны ёслолын үед бүх овгийнхон тоглодог ёслолын бүжиг бол бөөгийн тахилгын үйл ажиллагаанд бөөгийн бүжиг нь шашны шинж чанартай бүжиг юм. Энд гарч буй “Ихэ Нэнэн” нь гурван жилд нэг удаа болдог овгийн хурал бөгөөд нэг бүлэгт 10 гаруй хүн байна. Нэг хүн голд нь, бусад нь хөтлөлцөн дугуйран бүжиглэдэг. Эрт дээр үед уг овог, ургийн бичгээ уламжлахаар нэг овог цугларах үед энэ бүжгийг хийж байснаас үүсжээ.

3. Эвенк бүжиг

Эвенк буюу “ewenki” гэдэг нь “уулаар сууж буй хүмүүс”, “ууланд амьдардаг хүмүүс” гэсэн утгатай. Түүхэн хөгжлийнхөө явцад эвенк үндэстэн уул, ойгоо орхин бэлчээрийн тал, хөндийд нүүдэллэн ирж амьдрах болсон ч “эвенк” хэмээх нэр нь уул, ой модтой нягт холбоотой эвенкчүүдийн эртний түүхээс улбаатай юм. Энд нэгэн түүхийг сонирхуулахад Монгол Улсын цаатангууд өөрсдийгөө эв маллар гэж нэрлэх бөгөөд энэ нь цаа маллагч гэсэн утгатай үг гэж тайлбарлах бөгөөд (Сыртыпова, Наранцэцэг 2023, 174) эвенк үндэстэнтэй үгийн дуудлагын хувьд ойролцоо байгаа нь анхаарал татна.

Эвенк үндэстэн нь хагас ан агнуурын амьдралтай ард түмэн бөгөөд тэд үе удмаараа Их Хянганы нурууны ой бараадан амьдарч, цаа буга өсгөж амьжиргаагаа залгуулж ирсэн тул Хятадад цаа буга тэжээдэг цорын ганц угсаатан юм.

Эвенкчүүд Ая бүжиг (эмэгтэйчүүдэд зориулсан ёслолын бүжиг), Аидаха шилэнг (эрэгтэйчүүдийн дуэт бүжиг, зэрлэг гахайн тулааныг дуурайсан зугаа цэнгэлийн бүжиг), Аханба бүжиг (эмэгтэйчүүдийн бие даасан бүжиг), Орижи бүжиг (хунгийн бүжиг), Ан агнуурын бүжиг, Нинакен бүжиг (нохой зодоон бүжиг), Баленад бүжиг (барыг хазаж, тоглож байхыг дуурайсан бүжиг), Икан бүжиг (галын бүжиг) гэх мэт олон зүйл бүжигтэй. Тэдний дундаас ард нийтээрээ бүжиглэдэг бүжгээ “Нүгеле” гэж нэрлэх бөгөөд энэ нь эвенк хүмүүсийн зүрх сэтгэлтэй, зоригтой зан чанар, өөдрөг зан чанарыг бүрэн илэрхийлсэн зоримог өгүүлэмжтэй. “Нүгеле” бүжгийг ихэвчлэн эмэгтэйчүүд бүждэг. Бүжгийн алхмууд нь өвөрмөц, эрч хүчтэй, хэмнэлтэй, ан агнуурын дуу, бүжгийн анхдагч хэлбэрээс ан амьтны архирах, шувуудын дуудлагын дохиог дуурайх, тойрог тогтолцоог хадгалах зэрэг ан агнуурын бүжгийн онцлогтой (Лю Жунгуо 2018, 89).

Ан агнуурын бүс нутагт ихэвчлэн орой галын дэргэд бүжиглэдгээрээ дагуурын “Лури жилэ” бүжигтэй адил боловч “Бенгнук” (гармоника) хэмээх өвөрмөц хэмнэлтэй хөгжмийн зэмсгээр хөөмийлөн дуулж бүжиглэдгээрээ үндэстний өвөрмөц хэв маягийг харуулж байдаг.

Эвенкийн “Аханбай” бүжиг тусгайлсан хөгжмийн аягүй, дуудлагаар хэмнэлийг бий болгодог бөгөөд дуудлага болон хөдөлгөөнийг солбих зарчмаар явагддагаараа бусад үндэстний бүжгээс ялгардаг. Дуудлага болон бүжгийн хөдөлгөөн нь тогтсон дараалалгүй, нэг хүн удирдаж, бусад нь дагадаг тул удирдаач буюу ахлаачийн тухайн үеийн шийдэл зохиомжоор өөрчлөгдөж хувирч болдог. Гэсэн хэдий ч тухайн ахлаач дуудлага болон бүжгийн хөдөлгөөнийг үе улиран тоглож ирсэн тэр ёсоор явуулахыг ихэд хичээдэг (Цэрэнбат 2023). “Аханбай” нь дуудлага, хөдөлгөөн хоёрыг уялдуулан нэгэн зэрэг явагддаг онцлогтой. Тухайн бүжгийн хөдөлгөөн бүрт тусгай дуудлага байдаг бөгөөд зарим нь удаан, зарим нь хурдан, зарим нь хүчтэй, зарим нь уянгалаг байдаг. Дууны өнгө нь мөн өөр өөр байж болно: зарим нь өндөр нарийхан, зарим нь бүдүүн намуухан байх ба бүжгийн агуулга, үзүүлж буй бүжигчний сэтгэл хөдлөлөөс шалтгаална. “Дуудлага” нь ардын бүжигт маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь зөвхөн сэтгэл хөдлөлийг илэрхийлэх хэл биш, мөн хэмнэлийг нэгтгэж, бүжгийн хөдөлгөөнийг солих дохио юм. “Аханбай” бүжгийн дуудлагын хэмнэл нь харьцангуй нарийн төвөгтэй, олон янз боловч үндсэн дуудлагууд нь “Эжүү”, “Эжи”, “Эсү” гэх мэт бөгөөд эдгээр нь эвенкийн

ардын бүжгийн ан агнуурын шинжийг харуулдаг. “Агинмо”, “Эжима”, “Хоожилэ” гэх дуудлагууд нь дээрх дуудлагуудын хувилбар мэт харагддаг бөгөөд бүжгийн хэмнэлийн хөдөлгөөнт байдлыг нэмэгдүүлдэг.

Бүжиг эхлэх үед голдуу “Ханбай”, “Аханбай” гэх дуудлагаар эхэлдэг бөгөөд цаашид тогтсон дараалал шаардагддаггүй. Бүжгийг ихэвчлэн ахмад настнууд дуудлагаар удирдаж, бусад бүжигчид дагадаг. Дуудлага нь ихэвчлэн 2/4 хэмнэлтэй, дунд хурдтай байдаг бөгөөд бүжгийн оргил үед дуудлагын хэмнэл хурдсах бөгөөд алга таших, газар товших чимээтэй уялдан баяр хөөртэй уур амьсгалыг бүрдүүлдэг. Дуудлага нь бүжгийн хөдөлгөөн, бүжигчдийн сэтгэл хөдлөлөөс хамааран өөрчлөгддөг. “Аханбай” бүжгийн онцлог нь түүний хэмнэл нь эхний цохилтод хүчтэй байж, хоёрдугаар цохилт нь сул илэрдэг “хүч-сул” хэмнэлтэй байдаг. “Аханбай” бүжгийн дуудлагын дийлэнх нь амьтдын дуу авиаг дуурайсан байдаг бөгөөд жишээ нь “баавгайн тулаан”-ы хөдөлгөөн хийх үед хөлийг газар товших үед “Хамоо”, “Хамоо” гэх баавгайн дууг дуурайж дууддаг бол “Тагилэ” нь шувууны дууг дуурайсан дуудлага гэх мэтээр илэрч байдаг.

Хэлэлцүүлэг

Үндэстний бүжиг бол тухайн ард түмний соёл, сэтгэлгээг хадгалж байдаг оюуны бэлгэ тэмдэг, илэрхийлэл юм. Хөлөнбуйрын цөөн тоот ард түмний ардын бүжиг нь тэдний сэтгэл зүй, онцлогийг тод томруун тусгасан байдаг. Бид энэ хэсэгт эвенк үндэстний бүжгээр жишээ болгон үндэстний бүжигт соёлын элемент хэрхэн уламжлагддагийг өгүүлэх болно.

Эвенкчүүд ан агнах дуртай бөгөөд гол төлөв ан агнуураар амьжиргаагаа залгуулдаг байсан бөгөөд ан агнуурын элементүүдийг бүжигт шингээж, эвенкийн ардын бүжгийн өвөрмөц хэв маягийг бүрдүүлжээ. Эвенкийн ардын бүжиг бол үе дамжин өвлөгдөн ирсэн баялаг соёлын нэгэн хэсэг бөгөөд хамгийн онцлог бүжиг нь “Аханбай” юм. “Аханбай” бүжиг нь БНХАУ-ын өөртөө засах орнуудын соёлын өвийн жагсаалтын дөрөвдүгээр үе шатанд бүртгэгдсэн эртний уламжлалт ардын бүжгийн хэлбэр юм. Энэ бүжиг нь эвенкчуудын баяр ёслол, ургацын баяр, зочид хүлээн авах үеэр дуулж, бүжиглэн үзүүлдэг уламжлалт тоглолт билээ. “Аханбай” бүжиг нь өөрийн гэсэн онцлог бүхий бүжгийн алхмуудтай бөгөөд хэмнэл нь маш хүчтэй мэдрэгддэг. Хамгийн гол, бусдаас ялгардаг онцлог нь тухайн нөхцөл байдалд тохируулан дуу, үгийг шууд зохиож, эгшиглэнтэй, эрхэмсэг аялгуугаар баялаг байдаг оршино. Эвенк бүжгийн үндсэн хөдөлгөөн нь өдөр тутмын амьдралын хэв маягаас сэдэвлэсэн байдаг. Биеийн дээд биеийн хөдөлгөөнүүд нь үс самнах, толь харах, ханцуй шамлах, бүс бүслэх зэрэг байхад, хөлийн хөдөлгөөнүүд нь эртний уламжлалт “нэг хөлөө газар товшиж алхах” болон түүний дараагийн шатны хөгжүүлэлт болох “хөлийг ойртуулан алхах” гэх мэт жигд алхалттай, хөдөлгөөн нь нэг гар нь бүсэлхийгээрээ, нөгөө гар нь савлан, бие нь гарын хөдөлгөөнтэй уялдан урагш хөдөлдөг. Энэ бүжгийн хөдөлгөөнүүд нь эвенкийн эмэгтэйчүүдийн өгөөмөр, хөгжилтэй зан чанарыг тод томруун харуулдаг бөгөөд бүжгийн хэмнэл нь хүчтэй, халуун дулаан уур амьсгалтай, амьдралын баялаг уур амьсгалыг шингээсэн байдаг.

Харин дагуурын бүжиг нь голчлон дуутайгаа зэрэгцэн явах бөгөөд дуунууд нь байгалийн үзэмжийг магтан дуулсан, нийгмийн ёс суртахууныг магтан дуулсан,

сайхан үзэл санааг илэрхийлсэн агуулгатай байдаг. Бүжгийн дундуур амьтны хашгирах дууг дуурайсан цөөн хэдэн авиаг эс тооцвол ихэнх утгыг нь тодорхой бус, дуудлагын тэмдэг нь ихэвчлэн хоёр цохилттой байдаг. Хоёр хүн ээлжлэн дуудаж, бүжигчид дуудлагын дохиог хэмнэл болгон ашигладаг нь хөдөлгөөний хэмнэлийг нэмэгдүүлээд зогсохгүй, уур амьсгалыг өргөх, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх, дамжуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Одоо эвэнк үндэстний бүжигт ард түмний соёл сэтгэлгээний онцлог хэрхэн тусдагийг авч үзье.

Эвенкичүүд дуулж бүжиглэхдээ гарамгай. Бидний хээрийн судалгааны явцад ямар нэгэн тусгай баяр ёслол, зан үйл болоход үргэлж үндэстний бүжгээ хийж байгаагаас ажвал тэдний хувьд бүжиглэх нь амьдралын салшгүй нэг хэсэг нь болжээ. Бүжиглэхэд хүйс, нас харгалздаггүй, бүх нийтийн энтертайнмент үйл ажиллагаа гэж хэлж болно. Эвенк үндэстний бүжиг анх үүссэн цагаасаа л амьдралд гүн гүнзгий шингэсэн гэж үздэг. Бүжгийн бүх бүтээл бодит амьдрал, үндэстний үйлдвэрлэл, амьдрал ахуйтай нягт холбоотой ажээ. Уламжлалт үндэстний их баяр наадам буюу ургац хураалтын улирал, тахилгын үеэр, хүүхдийн даахь үргээх ёслол, хурим найрын өдрүүдэд тэд үндэстний хувцсаа өмсөж, нэг дор цугларч, хөгжөөн баясгаж, сэтгэл санаагаа өөрсдийн уран бүтээлээрээ илэрхийлж байв.

Эвэнк хүмүүс эрт дээр үеэс бөө мөргөлд итгэдэг байжээ. Тэдний оюун ухаанд нар, сар, салхи бороо, аянга цахилгаан, уул ус, ургамал, шувууд, амьтад бүгд бурханлаг шинж чанартай, бүх зүйл сүнстэй, хүн болон бүх зүйл нийтлэг байдаг. Иймээс эвэнк үндэстний амьдрал ахуйд тахил өргөх үйл ажиллагаа өрнөж, хүн зоныг идээ будаа элбэгтэй, амар тайван амьдралыг ивээж, өвчин зовлон, зовлон бэрхшээлээс хол байхыг бурхандаа залбиран залбирдаг. Эвэнкийн тахилын бүжгүүдийн хамгийн төлөөлөл нь “Икан” бүжиг бөгөөд энэ нь галын эргэн тойронд тоглодог цагираг бүжиг тул үүнийг “галын” бүжиг гэж нэрлэдэг. Эвэнк хүмүүсийн амьдралд бүжиг нь “гал”-тай нягт холбоотой байдаг бөгөөд хүмүүсийн байгаль дэлхийгээ шүтэх, гал тахих, Галын бурханд мөргөх зэрэг хөдөлгөөнийг дүрсэлсэн байдаг ч ерөнхийдөө “Икан” бүжгийг ургац хураах, ангаас буцаж ирэх, хурим хийх зэрэгт зориулж хийдэг.

Дүгнэлт

Дагуур, эвэнк, орчоон бол БНХАУ-ын хойд хэсэгт орших, харьцангуй цөөвтөр хүн амтай, өнө эртний түүхтэй, соёл урлагийн баялаг уламжлалтай үндэстний цөөнх юм. Тэд өөр өөрийн үндэстний хэл соёлоо хадгалахын зэрэгцээ өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой аж төрсөөр иржээ. Энэ гурван үндэстний түүхэн хөгжлийн явцад соёлын баялаг утга агуулга, уран сайхны хэв маягийг агуулсан бүжгийн өвөрмөц хэлбэрүүдийг бий болгожээ.

Хөлөнбуйрын цөөн тоот үндэстний бүжгийг бусад ойн гаралтай угсаатны бүжигтэй тухайлбал, Монгол Улсын буриад, ойрад угсаатны бүлгийн бүжигтэй харьцуулж үзвэл, бүжгийн хөдөлгөөний хувьд зан үйлийн олон янз хөдөлгөөнөөс ан агнуурын үйл хөдлөлийг илэрхийлсэн байдал давамгайлж байна.

Хэдий тийм боловч уламжлалт ардын бүжгийн хөдөлгөөн нь орчин үед илүү тайзны урлагтай хосолсон буюу тайзны бүжигт шахагдсан байдалтай болж, дуудлагын дохионы утгын удамшил ч үндсэн агуулгаа хадгалж чадахаа больсон нь

судалгааны явцад ажиглагдаж байв. Иймд Хөлөнбуйрын гурван жижиг үндэстний бүжгийн утга санааг хадгалсан өвлөн уламжлагчийг олноор сургаж, уламжлалт ардын бүжгийг үндсэн хэлбэр агуулгаар нь хадгалж үлдэхэд бодлогоор анхаарах цаг болжээ.

Ном зүй

- Асру. 2018. “Эвэнк хүмүүсийн бүжгийн төрөл, хэлбэрийн товч дүн шинжилгээ.” *Урлаг судлал сэтгүүл*. 2018 оны 1 дэх дугаар: 87-96.
- Ван Жяо. 2004. “Дагуурчуудын анхны дуу бүжгийн үлдэгдэл -Хакумайл.” *Урлаг судлал сэтгүүл*, 2004 оны 4 дэх дугаар: 64-75.
- Лю Жунгуо. 2018. “Эвэнк үндэстний ардын бүжиг, хөгжмийн урлагийн судалгаа.” *Урлаг шүүмжлэл сэтгүүл*, 2018 оны 2 дахь дугаар: 88-103.
- Содном Н., Гэрэл Б. 2023. *Барга, буриад, эвенк, орчоон бүжгийн судалгаа*. Ред. Эрдэнэцэцэг Ш. Улаанбаатар: Мелон хэвлэх үйлдвэр.
- Сыртыпова, С.-Х.Д., Наранцэцэг Д. 2023. “Оленеводы дархатской котловины, или как живет малочисленный народ Монголии цаатаны.” *Этнография*. 2023. 2(20): 163–188. [https://doi.org/10.31250/2618-8600-2023-2\(20\)](https://doi.org/10.31250/2618-8600-2023-2(20))
- Төвийн Үндэстний Их Сургууль. 1974. “Хятадын үндэстний цөөнхийн товч танилцуулга: Монгол, Дагуур, Эвэнк, Орчоон.” *Төвийн Үндэстний Их Сургуулийн дотоод хэвлэл*.
- Ү Я жи. 2006. “Сүүлчийн домог: Орчооны соёлын судалгаа.” *Төвийн Үндэстний Их Сургуулийн дотоод хэвлэл*.
- Хэ Вэнжун. 2013. “Дагуурчуудын уламжлалт ардын дуу, бүжгийн Дагуур нэрсийн тухай ярих нь.” “*Хятадын хөгжим*” эрдэм шинжилгээний бичиг 2013 оны 4 дэх дугаар: 178-183.
- Эрдэнэцэцэг, Ш. 2023. “Редакторын үг.” *Барга, буриад, эвенк, орчоон бүжгийн судалгаа*. Улаанбаатар.

Ярилцлага:

- Цэрэнбат (65 настай, эвенк үндэстэн)-тай хийсэн ярилцлага. БНХАУ-ын Хөлөнбуйр хотын Эвэнк үндэстний өөртөө засах хошуу, 2023.8.6.
- Ли Вэй вэй (БНХАУ-ын Хөлөнбуйр Дээд Сургуулийн багш, дагуур үндэстэн, 46 настай)-тэй хийсэн ярилцлага. Хөлөнбуйр Дээд Сургуулийн Урлагийн танхим, Дагуур үндэстний тайзны бүжгийн уралдаан, 2023.5.23.
- Мин Сү линь (БНХАУ-ын Хөлөнбуйрын орчоон үндэстэн, 80 настай)-тэй хийсэн ярилцлага. Хөлөнбуйрын түүх судлах газар, 2023.8.11.